



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 84

Хэрлэн сум

Г Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний
бодлого хариуцсан мэргэжилтний сул орон
тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзول болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо (68,9) авсан Энх-Амгалангийн Баярмааг аймгийн Засаг даргын Тамгын газрын Аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Э.Баярмааг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА

